

Tridumkey

ПИН БЛОК ГАРГАХ ЗААВАР


1. Ямар тохиолдолд пин код блоклогдох вэ ?

Та пин кодоо алдаатай, буруу оруулах бүрт токен төхөөрөмж дотор тоологдож хэрвээ Пин кодыг 10 удаа буруу хийвэл пин код блоклогдлоо алдаа заах болно . Пин блок гаргах SOPIN кодыг мөн 10 удаа буруу хийсэн тохиолдолд таны USB токен(Тээгч) төхөөрөмж түгжигдэн доторх мэдээллийг ашиглах боломжгүй болох учир та дахин бичиг баримтаа бүрдүүлэн шинээр үүсгүүлэх буюу худалдаж авах шаардлагатай болохыг анхаарна уу.

2. Пин блок гаргахад юу хэрэгтэй вэ ?

Анх тоон гарын үсэг үүсгүүлэн авахад манай оффис дээр ирсэн хэрэглэгчээр "Пин код" болон пин блок гаргах зориулалт бүхий "50 пин" кодуудыг зохиолгон жижиг карт дээр бичүүлэн өгч явуулдаг. Тоон гарын үсгийн гэрчилгээний энэхүү кодуудыг сунгалт хийлгэх үедээ мөн Tridumkey client програм дээр та өөрөө өөрчилж байгаагүй бол анх зохиож, карт дээр тэмдэглэж авсан **SO пин** кодоо ашиглан Tridumkey client программын "Пин блок гаргах" сонголтоор шинэ пин код зохиох боломжтой.

Анхааруулга: Хэрвээ таны USB токен төхөөрөмж дээрээ "Tridumkey" логотой бол "Пин код"-ыг зохиохдоо 8 оронтой тоо харин "50pin" код нь тоо үсэг холилдсон 8-12 оронтой байх хэрэгтэйг зөвлөдөг.



3. Пин блок гаргах "50 пин" кодыг мартаж тэмдэглэсэн картаа олохгүй, хаясан тохиолдолд юу болох вэ ?

Манай байгууллагын зүгээс хэрэглэгчдийн нууцлал, аюулгүй байдлыг хангахын тулд "Пин код" болон "50 пин" кодуудыг хадгалж авч үлдэхгүй бөгөөд **ЗӨВХӨН** таны USB токен(тээгч) төхөөрөмж дотор үүсдэг, бид зайнаас ямар нэг байдлаар солих, мэдэх боломжгүй.

Та "50 пин" кодоо мартсан , тэмдэглэсэн картаа хаясан тохиолдолд бидний зүгээс дахин үүсгэх ресет хийх боломжгүй .

"50 пин" кодыг 10 удаа буруу оруулснаар тухайн тээгч төхөөрөмж түгжигдэн, хэрэглэгч дахин бичиг баримтаа бүрдүүлэн шинээр тоон гарын үсгийн гэрчилгээг худалдаж авах шаардлагатай болох тул өөрийн мартажгүй код эсвэл бусдад мэдэгдэхгүй газар хадгалж, тэмдэглэж авахыг зөвлөдөг.

ТАНЫ КОМПЬЮТЕРТ TRIDUMKEY CLIENT ПРОГРАМ СУУСАН БАЙХ ШААРДЛАГАТАЙ

1.1 TRIDUMKEY CLIENT ПРОГРАМ

Хэрвээ та компьютертээ **client программ** суулгаагүй бол дараах холбоосоор орж суулгана уу.

Windows 10 ,11 үйлдлийн системтэй бол :

<https://downloads.tridumkey.mn/client/TridumKeyClientSetup.exe>

Windows 7,8 үйлдлийн системтэй бол:

<https://downloads.tridumkey.mn/client/TridumKeyClientSetup271.exe>


Програм суулгах **гарын авлагыг** дараах линкээр орж харна уу.

https://tridumkey.mn/wp-content/uploads/2023/10/Windows10_11_installation.pdf


Tridumkey Client программыг ажлуулж ,USB токен төхөөрөмжийг компьютерт залгана.




Та компьютерын дэлгэц дээрээсээ "Tridumkey Client" программын лого дээр 2 товшноор програм ачааллаж доорх зурагт харагдаж буй хэлбэрээр таскбарлуу шилждэг.



Компьютерийн дэлгэцний баруун доод булан буюу хэл сонголтын зүүн талд байрлах сум дээр дарж ажиллаж буй программууд дотроос Tridumkey client программын лого дээр 2 товшноор программын ажиллах талбар томоор нээгдэх болно.




"Пин блок гаргах" сонголтыг хийгээрэй. Хэрвээ таны компьютер дээр "Tridumkey" програмаас өөр тоон гарын үсгийн ижил төрлийн /Esign, Docsigner, Monpass зэрэг/ програм ажиллаж байгаа бол заавал бүрэн хаах шаардлагатайг анхаарна уу!



“Пин код” зохиох цонхны доор байрлах “PIN харуулах” сонголтыг зөвлөснөөр пингээ хэрхэн оруулж байгааг харах боломжтой

“Пин блок гаргах” цонх зурагт харуулсан хэлбэрээр гарч ирнэ.

Пин блок гаргах SO пингээ /SO пин код нь 8-12 оронтой тоо үсэг оролцсон байх боломжтой /эхний SOPIN талбарт оруулж дараагийн 2 Шинэ PIN талбарт шинээр зохиож буй 8 оронтой тоо байхыг анхаарна уу.



SO пин кодоо зөв оруулж пин блокыг амжилттай гаргасан тохиолдолд **“PIN шинээр үүсгэгдлээ!”** цонх гарч ирэх болно.

Нэмж асууж тодруулах зүйл байвал ажлын өдрүүдээр 9-18 цагийн хооронд манай лавлах 7012-0722 дугаараар болон “Tridum Key – Цахим гарын үсэг” фэйсбүүк пэйж хуудасны чатаар холбогдоно уу.